



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж,  
үйлчилгээг шилжүүлэн, зохицуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/318 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Налайх дүүргийн эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 313 дугаар албан бичгийн дагуу тус дүүргийн эх барих, эмэгтэйчүүд, нярайн яаралтай болон төлөвлөгөөт хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээг 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс 08 дугаар сарын 11-ний өдрийг дуустал Амгалан амаржих газарт шилжүүлсүгэй.

2. Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж, үйлчилгээг түр шилжүүлэн, зохицуулах чиглэлийг хавсралтаар баталсугай.

3. Эх барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээг түр хугацаагаар шилжүүлэх бэлтгэл ажлыг хийж, эх, барих эмэгтэйчүүд, нярайн тусламж, үйлчилгээний тасралтгүй, байдлыг ханган ажиллахыг Налайх Эрүүл мэндийн төвийн дарга (Л.Байгал), Амгалан амаржих газрын дарга (Ц.Батболд), Багахангай эрүүл мэндийн төвийн дарга (Х.Ганбат)-д тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэн зохицуулалт хийж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Б.Батцож)-т даалгасугай.

ДАРГА



П.ЭРХЭМБУЛГАН

1550010239

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 06 дугаар сарын 25 ны өдрийн  
.....191..... дугаар тушаалын хавсралт



Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж, үйлчилгээг  
түр шилжүүлэн, зохицуулах чиглэл

Нэг. Нийтлэг үндэслэл

Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/318 тушаалыг хэрэгжилтийг хангах, Налайх дүүргийн эрүүл мэндийн төвийн эх барих эмэгтэйчүүдийн тасагт ариутгал халдваргүйтгэл засварын ажил эхлэх өдрөөс дуусах хугацаанд эх барих эмэгтэйчүүд, нярайн яаралтай болон төлөвлөгөөт хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээнд энэхүү чиглэлийг баримтлана.

Хоёр. Тусламж, үйлчилгээг түр шилжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд

2.1. Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж, үйлчилгээг түр шилжүүлэх бэлтгэл ажлыг 2024 оны 06 дугаар сарын 27 ны өдрийн дотор багтаан хийж, дуусгасан байх,

2.2. Зохицуулалтад оролцож буй эрүүл мэндийн байгууллагууд тусламж, үйлчилгээг түр шилжүүлэн, зохицуулах багийг тушаалаар томилж, мэдээлэл солилцох хүснэгтийг гаргаж, багийн ахлагч, эмч, холбогдох албан тушаалтнуудыг оруулсан цахим мэдээлэл үүсгэн, тусламж, үйлчилгээг зохицуулах

2.2. Дүүргийн эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад байдаг жирэмсэн эх, хяналтын өвчтөн, засвар үйлчилгээ хийх хугацаанд амаржих эмэгтэйчүүдийн мэдээлэлийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дүгээр тушаалын дагуу жирэмсэн эхийн бүртгэлийн дагуу гаргаж, Амгалан амаржих газарт хүлээлгэн өгөх,

2.3. Өндөр эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдийг жирэмсэн эхчүүдийг Амгалан амаржих газрын эх барих эмэгтэйчүүдийн эмч нартай хамтран урьдал үзлэгт хамруулан шаардлагатай тохиолдолд хэвтэн эмчлүүлэх.

2.4. Дүүргийн эрүүл мэндийн төвийн өндөр эрсдэлтэй эхийн хяналт хариуцсан болон өрхийн эмч нарт жирэмсний хяналтад байгаа болон шинээр хяналтад орж буй эмэгтэйчүүдэд түр хугацааны зохицуулалтыг танилцуулан, төрөлт, жирэмсний аюултай шинж тэмдэгийн талаар болон тусламж, үйлчилгээг цаг алдалгүй авах талаар мэдээлэл, зөвөлгөө өгч гарын үсгээр баталгаажуулах. Амаржих газрын эх барих эмэгтэйчүүдийн эмч нартай уялдаа холбоог сайжруулан, мэдээлэл солилцох цахим групп үүсгэн хамтран ажиллах үүрэг чиглэл өгч баримтжуулах.

2.5. Дүүргийн эрүүл мэндийн төвийн төрөлжсөн мэргэжлийн эмч, түргэн тусламжийн болон өрхийн эмч нарт эх барих, эмэгтэйчүүд, нярайн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж үзүүлэх сургалтыг Амгалан амаржих газартай хамтран зохион байгуулж, тээвэрлэх боломжгүй үед дараагийн баг дуудах, утсаар зөвлөгөө авах, яаралтай тусламж, үйлчилгээний зураглал, алгоритмыг гарган, ашиглах боломжийг бүрдүүлэн, шаардлагатай газарт байршуулах. Амгалан амаржих газраас

томилогдон ирж ажиллаж буй эмч нарын цай, хоол, унаа , илүү цаг зэрэг зардлыг дүүргийн Эрүүл мэндийн төв хариуцна.

2.6.Түргэн тусламжийн машины бэлэн байдлыг хангах, эх барих, эмэгтэйчүүд, нярайн яаралтай тусламж үзүүлэх эм тариа тоног төхөөрөмжийг ашиглах, халдварын сэргийлэх хяналтын талаар сургалтыг хийх, Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх тухай 2023 оны ЭМС-ын А/220 тушаалыг танилцуулж, тээвэрлэх үеийн хяналтын хуудас бэлтгэх,

2.7.Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээг түр хугацаанд шилжүүлж байгаа тухай мэдээллийг орон нутгийн Засаг захиргааны байгууллага, нутгийн иргэд, эх, түүний асран хамгаалагч, мэдээллээр хангах, тусламж, үйлчилгээг зохицуулах багийн холбоо барих утсыг ил байршлуулах .

2.8 Дүүргийн Засаг даргын тамгын газарт уламжлан Тэрэлж болон нутаг дэвсгэр ирж зусланд гарсан болон түр оршин байгаа явуулын иргэнд эх барих эмэгтэйчүүд, нярайн тусламж үйлчилгээний зохицуулалтын талаар мэдээллийг хэсгийн ахлагч хорооны ажилтнаар хүргүүлэх ажлыг зохион байгуулах.

**Гурав. Эх барих,эмэгтэйчүүд, нярайн тусламж, үйлчилгээг шилжүүлэн, зохицуулах хүрээнд**

3.1.Тусламж үйлчилгээг түр хугацаанд зохицуулах багууд өдөр бүр дүүргийн эрүүл мэндийн төвөөс шилжүүлсэн, амаржих газраар үйлчлүүлсэн, хэвтэн эмчлүүлээд гарсан, амаржсан эх, нярайн холбогдох мэдээллийг солилцож тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана.

3.2.Багууд мэдээлэл солилцож, тулгамдсан асуудлыг ярилцаж, шийдвэрлэх шаардлагатай тохиолдолд НЭМГ-ийн Эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргад мэдэгдэнэ,

3.4 Өндөр эрсдэлтэй жирэмсэний хяналтыг Налайх эрүүл мэндийн төв хариуцан хийж, өрхийн болон амаржих газрын эмч нартай уялдаа холбоотой ажиллаж, манас татлын урьдал болон, хүндрэх эрсдэлтэй жирэмсэн эхийг гараас гарт хүлээлгэн өгнө.

3.5.Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан “Жирэмсэн, төрөх, төрсний дараа тусламж, үйлчилгээ” үзүүлэх Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/318, “Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх” тухай 2023 оны А/ 220, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай 2019 оны А/406 тушаал, Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээнд тавигдах MNS 7014 :2023 стандарт болон яаралтай тусламжийн холбогдох тушаал, удирдамж зааврыг мөрдөж, Эх барих эмэгтэйчүүд, нярайн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлнэ.

3.6 Эх барих эмэгтэйчүүд, нярайн тээвэрлэх боломжгүй үед удирдлагын багт мэдэгдэн Амгалан амаржих газрын холбогдох эмчээс цахимаар зөвлөгөө авах, тээвэрлэх боломжгүй үед дараагийн багийг дуудах, тасаг нэгжид яаралтай тусламж үзүүлэх боломжийг бүрдүүлэн ажиллах, өвчтөнг биеийн байдлыг тогтворжуулж тээвэрлэх.

3.7 Мэргэжлийн баг дуудаж тусламж үйлчилгээг үзүүлэх, дуудагдан ирж багийн унаа шатахуун, хоол, дуудлагын эмч нарын илүү цаг зэрэг зардлыг дуудлага дуудсан Эрүүл мэндийн төв хариуцан холбогдох зардлаас гаргана.

3.8. Дүүргийн болон өрхийн эмч нар амаржих газраар үйлчлүүлсэн, хэвтэн эмчлүүлээд гарсан, амаржсан эх, нярайд гэрээр идэвхтэй эргэлт хийх, төрөлжсөн мэргэжлийн эмч нарын заасан эмчилгээ, сувилгаа, оношилгоо үйлчилгээг үргэлжүүлэн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж эргэх холбоотой ажиллана.

3.9. Эх барих эмэгтэйчүүд, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээг тасралтгүй чирэгдэлгүй үзүүлэх, үйлчүүлэгчээс тусламж, үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааг авч түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авах,

3.8. Эх барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээтэй холбоотой таагүй ноцтой тохиолдол бүртгэгдвэл (дутуу, амьгүй, гэрийн, хяналтгүй төрөлт гэх мэт) 2 байгууллагын ЭМТҮЧАБ-ын алба мэдэлэл солилцон, шалтгаан, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийг судлан, давтан гарахаас сэргийлэх ажлыг зохион байгуулах,

3.9. Түр журмын хэрэгжилтэд хяналт тавьж, бүртгэгдсэн тохиолдлыг судлан тулгамдсан асуудлыг шийдвэрлэн ажиллана.